



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/356

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Буянт-Ухаа" Олон улсын нисэх буудлын барилгын дээврийн засвар хийж гүйцэтгэх (ИНҮТ/ХО/НТШ/А-09/21) гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

Л.Отгонжаргал

"Буянт-Ухаа" нисэх буудлын ашиглалтын хэсгийн дарга

Гишүүд:

Д.Мөнхцог

Аэродром, барилга байгууламжийн ашиглалтын албаны Барилга, байгууламж засварын хэсгийн дарга

С.Эрдэнэбаатар

Аэродром, барилга байгууламжийн ашиглалтын албаны Барилга, байгууламжийн засварын хэсгийн инженер

Х.Рэнцэнпил

Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны төсөвчин инженер

Б.Оюунчимэг

Худалдан авах ажиллагааны тасгийн ахлах инженер

Ц.Цацрал

Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны ахлах нягтлан бодогч

С.Эрдэнэчимэг


Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны нярав

2. Энэхүү гэрээний хүрээнд гүйцэтгэсэн ажлыг гэрээнд заасан тоо хэмжээ, техникийн тодорхойлолт, холбогдох баримт бичиг, дурдсан шаардлагуудын дагуу хүлээн авах, санхүүгийн бүртгэлд тусгуулах, комиссын акт,

холбогдох бусад материалыг бүрдүүлж, 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Худалдан авах ажиллагааны тасагт хүргүүлэхийг ажил хүлээн авах комисс (Л.Отгонжаргал)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Л.Тайванжаргал)-т даалгасугай

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ